| | хэрэгсэл шалгаж, баталгаажуулах сорилт, туршилт явуулах "Жишилтийн полигон" байгуулах | | | "Жишилтийн полигон"-д геодезийн хэмжих хэрэгслийг баталгаажуулдаг. | хэмжих хэрэгсэл шалгаж, баталгаажуулах, сорилт, туршилт явуулах "Жишилтийн полигон"-ы байгууламжийн зураг, төсөв хийх, ажлын даалгавар боловсруулж, батлуулна. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлыг эхлүүлнэ.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Дунд болон техникийн нарийвчлалтай геодезийн хэмжих хэрэгсэл шалгаж, баталгаажуулах, сорилт, туршилт явуулах "Жишилтийн полигон"-ыг хүлээн авч, хэвийн үйл ажиллагааг хангана. | зураг зүйн ерөнхий газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-нд заасны дагуу геодезийн хэмжил зүйн лабораторийн дунд болон техникийн нарийвчлалтай геодезийн хэмжих хэрэгсэл шалгах, баталгаажуулах полигон байгуулах ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн зарлалыг 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд зарлаж, амжилтгүй болсон.<br>Тендерийг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр дахин зарлан 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр нээсэн ба тендерт 2 хуулийн этгээд оролцож Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтад заасны дагуу "Геосет" ХХК нь "Хамгийн сайн" үнэлэгдсэн тендерээр шалгарсан тул гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 1/1423 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Гэвч тус компаниас гэрээт ажлын санхүүжилт хүрэлцэхгүй, нэмэлт санхүүжилт хүссэн тухай 2025 оны 49/25 дугаартай албан бичиг ирүүлсэн байна. Тус газраас нэмэлт санхүүжилт олгох боломжгүй, 28,200,000 төгрөгөөр дээрх ажлыг гүйцэтгэх эсэх шийдвэрээ ирүүлэх тухай 2025 оны 1/1781 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Тендерт шалгарсан "Геосет" ХХК-иас 2025 оны 55/25 дугаар албан бичгээр дээрх ажлыг гүйцэтгэх боломжгүй шийдвэрээ эргэн мэдэгдсэн тул tender.gov.mn цахим системд оруулсан үр дүнг цуцалж, 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр www.tender.gov.mn цахим системд тендерийг дахин зарласан.<br>Тендерийг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр нээхэд нэг ч оролцогч ирээгүй тул тендер амжилтгүй болсон. Геодезийн үйлдвэр, үйлчилгээ эрхлэн явуулах тусгай зөвшөөрөлтэй "Некст Жи Ай Эс" ХХК-тай зөвшилцөж гүйцэтгүүлэхээр захиалагчид зөвлөмж хүргүүлэв. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5.1.2 | Тоон нивелир худалдан авах (Инвар рейк, бусад дагалдах иж бүрдлийн хамт) | Урсгал төсөв | 1 багаж | Лабораторид шалгалт тохируулгад одоо ашиглаж буй эт алон автомат нивелир 1км нүүлтийн дундаж квадрат алдаа 1.0мм нарийвчлалтай ба лабораториор шалгалт, тохируулга хийлгэхээр ирж буй хэмжих хэрэгслүүд 0.3мм-ээс дээш өндөр нарийвчлалтай байдаг. | **Эхний хагас жилд:**<br>Тоон нивелир (Инвар рейк, бусад дагалдах иж бүрдлийн хамт) худалдан авах ажлын даалгавар боловсруулж, батлуулна. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, нийлүүлэх ажлыг эхлүүлнэ.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Лабораторид өндөр нарийвчлалын эталон тоон нивелирийг шалгалт, тохируулгын үйл ажиллагаанд ашиглана. | Лабораторийн том, дунд, жижиг оврын коллиматорын шалгалт тохируулгад ашигладаг эталон багажны нарийвчлалыг сайжруулахаар Геодезийн хэмжил зүйн лабораторийн багаж баталгаажуулалтад шаардлагатай багаж худалдан авах (Тоон нивелир) тендерийн зарлалыг 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд ажлын 10 хоногийн хугацаатай нийтэлж, тендерийн нээлтийг 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 14 цаг 30 минутад нээж, хамгийн сайн тендер ирүүлсэн "Инженер геодези" ХХК шалгарч 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр 2025/36 дугаар гэрээ байгуулсан.<br>Гэрээнд заасны дагуу тоон нивелир, бусад дагалдах хэрэгслийг техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагын дагуу гэрээ дүгнэсэн актаар 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр хүлээн авсан. | |
| 2.5.1.3 | Геодезийн хэмжил зүйн лабораторийн итгэмжлэл сунгуулах | Үйл ажиллагаа | 1 удаа | 2022 онд Геодезийн хэмжил зүйн лаборатори магадлан итгэмжлэгдсэн. | **Жилийн эцэст:**<br>MNS ISO/IEC 17025:2018 стандарт "Сорилтын болон шалгалт, тохируулгын лабораторийн чадавхид тавигдах ерөнхий шаардлага"-д нийцүүлэн геодезийн хэмжил зүйн лабораторийн итгэмжлэл сунгуулах хүсэлт, холбогдох материалын хамт Үндэсний итгэмжлэлийн төвд хүргүүлэх, итгэмжлэл авна. | Лабораторид 2025 оны 03 дугаар сарын 31-нээс 04 дүгээр сарын 01-ний өдрүүдэд Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/65 дугаар тушаалын хавсралтаар баталсан үнэлгээний ажлын хэсэг 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажилласан. Ажлын хэсгийн үнэлгээгээр дараах 3-н үл тохирол, 7-н зөвлөмжийг өгсөн. Үүнд:<br><u>Үл тохирол:</u><br>1. Ажилтны журам боловсруулах;<br>2. Тоног төхөөрөмжийн бүртгэлд мэдээллийг бүрэн оруулах;<br>3. Шалгалт баталгаажуулалтын гэрчилгээнд ашигласан арга аргачлалын талаар мэдээлэл оруулах;<br><u>Зөвлөмж:</u><br>1. Хэмжлийн эргэлзээг тооцоолдог болох;<br>2. Харьцуулалтын хэмжлийн үр дүнд анализ хийж зохих шалгуурт нийцэж байгаа эсэхийг тогтоох, лаборатори доторх харьцуулалт хийх – Үр дүнгийн үнэн бодит байдлыг хангах; | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. Тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспортын хөтлөлтийг сайжруулах;<br>4. Коллиматорын шалгалт тохируулга хийсэн бүртгэлдээ зөвшөөрөгдөх утгыг нэмж оруулан харьцуулах;<br>5. Гэрчилгээ болон бусад баримт бичиг дээр хэмжлийн нэгжийг тодорхой бичиж оруулах;<br>6. Итгэмжлэлийн хамрах хүрээнд EDM-ийн зайн хэмжлийн хамрах хүрээг нэмж оруулах;<br>7. Геодезийн хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийхэд гүйцэтгэхэд орчны температур, чийг даралтын нөлөө /даралт, температур/ тооцох шаардлагатай. Иймд эдгээр нөхцлийг хянах бүртгэх баталгаатай хэмжих хэрэгсэл дутмаг байна. Нэг хэмжих хэрэгсэл байгаа боловч шалгалт тохируулгад хамрагдаагүй. (MNS ISO/IEC 17025:2018 стандартын 6.3.5-т заасны дагуу).<br>Дээрх илэрсэн үл тохирол, зөвлөмжийг залруулах ажлын төлөвлөгөө боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Газрын даргаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу үл тохирол, зөвлөмжийг залруулан 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр 1/1518 дугаар албан бичгээр үнэлгээний ажлын хэсэг, итгэмжлэлийн үндэсний төвд хүргүүлсэн.<br>Үндэсний итгэмжлэлийн төвийн техникийн хорооны 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар үнэлгээний ажлын хэсгийн гаргасан тайланг хэлэлцүүлэн 4 жилийн хугацаатайгаар TL-V буюу шалгалт баталгаажуулалтаар давтан итгэмжлэлийг сунгахаар шийдвэрлэсэн. | |
| 2.5.1.4 | Жижиг оврын коллиматорын цилиндр тэгш ус солих ажлыг зохион байгуулах | Урсгал төсөв | 2 цилиндр тэгш ус | 2013 оноос хойш урсгал засвар хийгдээгүй. | **Эхний хагас жилд:**<br>Жижиг оврын коллиматорын 2 цилиндр тэгш усыг худалдан авах үнийн судалгаа хийж, солих ажлыг зохион байгуулна. | Геодезийн хэмжлийн багаж хэрэгсэл шалгаж тохируулах зориулалттай БНХАУ-д үйлдвэрлэсэн NCS-1 маркийн жижиг оврын коллиматорын 2 ширхэг цилиндр тэгш усыг сольж хэвийн ажиллагааг хангасан. | |
| 2.5.1.5 | Зай хэмжлийн жишилтийн полигоны 9 багана хоорондын зайг тодорхойлох өөвөл, | Үйл ажиллагаа | 2 багц хэмжилт | Төв аймгийн Номтын аманд байрлах Зай хэмжлийн жишилтийн | **Эхний хагас жилд:**<br>Төв аймгийн Номтын аманд байрлах Зай хэмжлийн жишилтийн полигоны 9 багана хоорондын зайг өндөр | Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан “Өвлийн улирлын хэмжилтийн албан томилолтын удирдамж”-ийн дагуу Зай хэмжлийн жишилтийн полигоны 9 багана хоорондын зайг өндөр нарийвчлалтай электрон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зуны улирлын хэмжилт гүйцэтгэх | | | полигоны багана хоорондын зайг 2009-2024 онд хийсэн. | нарийвчлалтай хэмжих хэрэгслээр өвлийн улирлын хэмжилтийг гүйцэтгэж, үр дүнг боловсруулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Төв аймгийн Номтын аманд байрлах Зай хэмжлийн жишилтийн полигоны 9 багана хоорондын зайг өндөр нарийвчлалтай хэмжих хэрэгслээр зуны улирлын хэмжилтийг гүйцэтгэж, үр дүнг боловсруулж, нэгтгэн тайлагнасан байна. | тахеометрээр тодорхойлох харьцуулсан хэмжилтийг ИНЕГ-ын Оношилгоо, хэмжил зүйн лаборатори, "Геосурвэй" ХХК-тай хамтран 2025 оны 01 дүгээр сарын 27-30-ны өдрүүдэд Төв аймгийн Номтын аманд байрлах "Зай хэмжлийн жишилтийн полигон"-нд MNS ISO/IEC 17123-4:2016 стандарт "Зай хэмжлийн багажинд шалгалт хийх заавар"-ын дагуу гүйцэтгэсэн.<br>Хэмжилтэд Sokkia фирмийн NET05AX маркийн өнцгийн 0.5 секунд, зай хэмжлийн 0.8 мм+1ppm, Topcon фирмийн OS101 маркийн өнцгийн 1 секунд, зай хэмжлийн 1.5 мм+2ppm, Trimble фирмийн S7 маркийн өнцгийн 1 секунд, зай хэмжлийн 1мм+2ppm тус тус нарийвчлалтай 3 электрон тахеометрийг ашигласан.<br>Үр дүнг MNS ISO/IEC 17123 цуврал стандартын 4 дүгээр бүлэгт заасны дагуу боловсруулсан. | |
| 2.5.1.6 | Улсын хэмжээнд хэрэглэгдэж буй геодезийн хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулах | Үйл ажиллагаа | 600 хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалт | 2024 онд 920 гаруй иргэн, аж ахуйн нэгж, иргэний 1116 хэмжих хэрэгсэлд шалгалт, тохируулга хийж баталгаажуулсан. | **Эхний хагас жилд:**<br>Геодезийн хэмжлийн 300 хэмжих хэрэгсэлд шалгалт, баталгаажуулалт хийж, гэрчилгээ олгон бүртгэлийг мэдээллийн санд оруулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Геодезийн хэмжлийн 300 хэмжих хэрэгсэлд шалгалт, баталгаажуулалт хийж, гэрчилгээ олгон бүртгэлийг мэдээллийн санд оруулсан байна. | Геодезийн хэмжил зүйн лаборатори эхний хагас жилийн байдлаар геодезийн хэмжих хэрэгслийн хэмжлийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор бүх төрлийн хэмжилт, зураглалын ажилд ашиглаж буй геодезийн хэмжлийн 1181 хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга, баталгаажуулалт хийж, 78,120,000 төгрөгийн орлого улсын төсөвт оруулсан. Үүнээс лабораторийн нөхцөлд том, дунд, жижиг оврын коллиматорыг ашиглан автомат нивелир-364 ш, тоон нивелир-62 ш, электрон тахеометр-137 ш, электрон теодолит-86 ш, лазер хэмжигч-16ш нийт 665 геодезийн хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт тохируулга хийж гэрчилгээ олгов. 41,057,000 төгрөгийн орлого улсын төсөвт оруулсан. | |
| 2.5.1.7 | Жишилтийн полигон дээр геодезийн хэмжих хэрэгслийг шалган хэмжилтийн үр дүнг боловсруулах, баталгаажуулах | Үйл ажиллагаа | 500 GNSS-ийн хүлээн авагч баталгаажуулах Мэдээллийн сан хөтлөх | 2024 онд 881 GNSS-ийн хүлээн авагчийг шалгаж, баталгаажуулсан. | **Эхний хагас жилд:**<br>Геодезийн хэмжлийн 250 GNSS-ийн хүлээн авагч шалган баталгаажуулж, гэрчилгээ олгон бүртгэлийг мэдээллийн санд оруулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Геодезийн хэмжлийн 250 GNSS-ийн хүлээн авагч шалган баталгаажуулж, гэрчилгээ | Геодезийн хэмжил зүйн лаборатори эхний хагас жилийн байдлаар геодезийн хэмжих хэрэгслийн хэмжлийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор бүх төрлийн хэмжилт, зураглалын ажилд ашиглаж буй геодезийн хэмжлийн 1181 хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга, баталгаажуулалт хийж, 78,120,000 төгрөгийн орлого улсын төсөвт оруулсан. Үүнээс Төв аймгийн Номтын аманд байрлах "Жишилтийн полигон"-д геодезийн хэмжлийн GNSS-ийн 489 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | олгон бүртгэлийг мэдээллийн санд оруулсан байна. | хүлээн авагчийн хэмжилтийн өгөгдлийг шалгаж баталгаажуулан гэрчилгээ олгон, багаж бүртгэлийн цахим системийн мэдээллийн санд давхцалыг шүүж, бүртгэл хөтлөн, шаардлагатай нэмэлт мэдээллийг оруулан 37,071,000 төгрөгийн орлогыг улсын төсөвт оруулсан. | |
| 2.5.1.8 | Аймгуудын ГХБХБГ, нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хэрэглэгдэж буй геодезийн хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулах | Үйл ажиллагаа | 40 багажны шалгалт, баталгаажуулалт хийж мэдээллийн сан хөтлөх /Аймгууд электрон тахеометр, нивелирээ акталсан учир өмнөх оны хэмжээнээс тоо буурсан../ | 2024 онд 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хэрэглэж байгаа нийт 60 хэмжих хэрэгсэлд шалгалт, тохируулга хийж баталгаажуулсан. | **Эхний хагас жилд:** Аймгийн ГХБХБГазарт хэрэглэгдэж байгаа геодезийн хэмжлийн 15 хэмжих хэрэгсэлд шалгалт, баталгаажуулалт хийж, гэрчилгээ олгон бүртгэлийг мэдээллийн санд оруулсан байна. **Жилийн эцэст:** Аймгийн ГХБХБГазарт хэрэглэгдэж байгаа геодезийн хэмжлийн 25 хэмжих хэрэгсэлд шалгалт, баталгаажуулалт хийж, гэрчилгээ олгон бүртгэлийг мэдээллийн санд оруулсан байна. | Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Говьсүмбэр, Дорноговь, Баянхонгор, Орхон, Өвөрхангай, Баян-Өлгий, Булган, Төв, Говь-Алтай зэрэг 9 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хэрэглэгдэж буй геодезийн бүх төрлийн өндөр, байрлал, өнцөг, зай хэмжлийн 32 хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалган хүлээн авч, баталгаажуулан, багаж бүртгэлийн цахим системийн мэдээллийн санд бүртгэж, шаардлагатай нэмэлт мэдээллийг оруулан, гэрчилгээ олгосон. | |
| 2.5.1.9 | Геодезийн хэмжил зүйн лабораторийн үйл ажиллагаанд Дотоод аудит явуулах | Үйл ажиллагаа | 1 удаа | Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавигдах шаардлага MNS ISO/IEC 17025:2018" стандартад заасны дагуу 2024 онд зохион байгуулсан. | **Жилийн эцэст:** MNS ISO/IEC 17025:2018 стандартын 8.8, "Чанарын гарын авлага"-ын бүлэг 2.9-д заасны дагуу Дотоод аудит явуулсан байна. | Хугацаа болоогүй<br>III улирал | |
| 2.5.1.1 | Геодезийн хэмжил зүйн лабораторийн үйл ажиллагаанд Удирдлагын дүн шинжилгээ хийх | Үйл ажиллагаа | 1 удаа | Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавигдах шаардлага MNS | **Жилийн эцэст:** MNS ISO/IEC 17025:2018 стандартын 8.9, "Чанарын гарын авлага"-ын бүлэг 2.10-т заасны дагуу дүн шинжилгээ хийсэн байна. | Хугацаа болоогүй<br>IV улирал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ISO/IEC 17025:2018" стандартад заасны дагуу 2024 онд зохион байгуулсан. | | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 2.6. Монгол Улсын нутаг дэвсгэрийг төрөл бүрийн масштабтай газрын зургаар зурагжуулах, газар зүйн нэрийг тодруулах** | | | | | | | |
| **2.6.1** | **1:1000-ны масштабтай тоон дэвсгэр зургийг шинээр гүйцэтгэх.** | **Улсын төсөв** | **1:1000-ны масштабтай тоон дэвсгэр зураг** | **Нийслэл, Өмнөговь аймгийн төв, 4 сумын төвийг ITRF2020 тогтолцоонд 1:1000-ны масштабтай тоон байр зүйн зургийг 2024 онд шинээр гүйцэтгэж байна.** | **ITRF2020 тогтолцоонд 21 аймгийн 330 сум, 45 суурин, нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай тоон байр зүйн зургийг шинээр гүйцэтгэсэн байна.** | | |
| 2.6.1.1 | 1:1000-ны масштабтай байр зүйн тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн санг шинэчлэх | Үйл ажиллагаа | 21 аймаг, нийслэл | 2024 онд Геопортал цахим системийн байр зүйн зургийн дэд сан, дэд бүтцийн дэд санг … мэдээллээр шинэчилсэн. | **Бүтэн жилд:**<br>21 аймаг, нийслэлийн 1:1000-ны масштабтай байр зүйн тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн сангийн шинэчлэлтэд хяналт тавьж, баталгаажуулна. | 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 01/157 дугаартай Нийслэлийн хот байгуулалт, хотын стандартын газраас ирүүлсэн нийслэлийн 1:1000-ны масштабтай байр зүйн зургийн шинэчлэлтийг хүлээн авч, шалгахад тухайн шинэчлэлт нь иргэн, аж ахуйн нэгж тус бүрээр хүлээн авснаа нэгтгээгүй ирүүлсэн байсан тул 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр НХБХСГ-т мэдэгдэж дахин засварлуулж ирүүлэхээр болов. | |
| 2.6.1.2 | Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодези, зураг зүйн ажлыг шалгаж хүлээн авах | Үйл ажиллагаа | Геодези, зураг зүйн ажлын үр дүн ирүүлсэн хүсэлтийн тоогоор | 2024 онд ААН-ийн ирүүлсэн хүсэлтэд хяналт хийж, дүгнэлтээр Геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгсөн. | **Эхний хагас жилд:**<br>Хүсэлт ирсэн тухай бүрд ажлыг шалгаж, үр дүнг Геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгсөн. байна.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Хүсэлт ирсэн тухай бүрд ажлыг шалгаж, үр дүнг Геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгсөн.байна. | "Геосан" ХХК, "Геокад" ХХК, "Монмэп" ХХК гүйцэтгэсэн "Нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох" НХААГ/20240103238 дугаар гэрээт ажлын дунд шатны тайланг ГЗЗХ-2025/01 дугаартай дүгнэлтээр 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр, засварлан ирүүлсэн дундын тайланд ГЗЗХ-2025/02 дугаартай дүгнэлт гарган 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр тус тус Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгөв. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Лэнд тест” ХХК-ийн “Өмнөговь аймаг Гурвантэс сум, Шивээхүрэн боомтын хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах” ажилд зориулсан 1:1000-ны масштабтай байр зүйн зураглалын ажлыг шалгаж 2025 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн ГЗЗХ/2025/03 дугаартай дүгнэлт гаргав.<br>“Геосурвэй” ХХК-ийн “Зуслангийн бүсийг төвийн бүстэй холбох хөнгөн галт тэрэг (LRT) нэвтрүүлэх төслийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах” ажилд зориулсан 1:500-ны масштабтай байр зүйн зураглалын ажлыг шалгаж 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн ГЗЗХ/2025/04 дугаартай дүгнэлт гаргав.<br>“Георадар” ХХК-ийн “Хэрлэн тооно” төслийн техник эдийн засгийн үндэслэлийн судалгааг шинэчлэх, тодотгол боловсруулах ажлын геодезийн суурь судалгааны ажлын байр зүйн зурагт зориулсан сүлжээний ажлын хээрийн хэмжилтийн тайланг шалгаж 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн ГЗЗХ/2025/05 дугаартай дүгнэлт гаргав.<br>“Геосет” ХХК-ийн Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Геодезийн байнгын цэг тэмдэгтийн хайгуул судалгаа, суулгалт, GNSS-ийн сүлжээний хэмжилт, бодолтын ажлын тайланг шалгаж 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ГЗЗХ/2025/06 дугаартай дүгнэлт гаргав.<br>“Агар Од инженеринг” ХХК-ийн гүйцэтгэсэн Хэнтий аймгийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураглалын ажлыг шалгаж 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ГЗЗХ/2025/08 дугаартай дүгнэлт гаргав.<br>“Геомастер” ХХК-ийн Ховд аймгийн Чандмань, Буянт, Дарви сумдын 1:1000-ны масштабтай байр зүйн зураглалын ажилд хяналт шалгалт хийхэд гарсан алдаануудыг засварлуулахаар 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 2/2006 дугаартай албан бичгийг хүргүүлэв.<br>“Классик лэнд” ХХК-ийн 2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн Нийслэлийн Баганхагай дүүргийн “Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажил”- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ын тайланг шалгаж 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн ГЗЗХ/2025/12 дугаартай дүгнэлт гаргав. | |
| **2.6.2** | **GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын сүлжээг өтгөрүүлэх, техник хангамж болон програм хангамжийн шинэчлэлтийг хийж нэгдсэн удирдлагын системд холбох** | **Улсын төсөв** | **GNSS-ийн байнгын ажиллагаатай 15 станц, нэгдсэн удирдлагын систем** | **2000-2024 онд Улсын хэмжээнд 48 станц суурилуулсан. “GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээг өтгөрүүлэх” ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулж ГЗБГЗЗЕГ-ын даргаар 2023 онд батлуулсан.** | **Байнгын ажиллагаатай суурин станц байгуулсан сум суурин газарт геодезийн хэмжил зураглалын ажлын нарийвчлал сайжирч тоон мэдээллийг хэрэглэгчдэд түгээх цахим тоглолцоог бий болгоно.** | | |
| 2.6.2.1 | Статик хэмжилтийн тэгшитгэн бодолтын онлайн боловсруулалтын системийн хэвийн үйл ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | 1 систем | GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээнд тулгуурлан статик хэмжилтийн тэгшитгэн бодолт хийдэг онлайн боловсруулалтын системийг 2019 онд хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>Онлайн тэгшитгэн бодолтын системийн хэвийн үйл ажиллагааг хангаж урт хугацааны өгөгдөл боловсруулалтын үр дүнг хадгалах, хамгаалах дүн | **Бүтэн жилд:**<br>MONPOS онлайн боловсруулалтын системийн тэгшитгэн бодолтын хэвийн үйл ажиллагааг хангана.<br>MONPOS онлайн боловсруулалтын системийн БАСС-уудын урт хугацааны өгөгдөл, хяналт шинжилгээний хэвийн үйл ажиллагааг хангана. | 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр байнгын ажиллагаатай суурин станцын удирдлагын болон өгөгдөл бүрдүүлэлтийн виртуал сервер дээр windows үйлдлийн системийн лицензийн эрхтэй холбоотой асуудал гарч БАСС-ууд болон MonPOS системийн үйл ажиллагаа доголдсон, үүнтэй холбогдуулан БАСС-ын засвар дамжуулалт болон статик хэмжилтийн тэгшитгэн бодолтын онлайн боловсруулалтын MONPOS систем ашиглагч иргэд, аж ахуй нэгжүүдэд цаг үеийн мэдээг бэлтгэн байгууллагын нүүр хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээллэсэн.<br>Тус асуудлыг 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр хэвийн ажиллагаанд оруулсан.<br>ГЗБГЗЗЕГ-аас 2024 онд шинээр байгуулсан байнгын ажиллагаатай 5-н аймгийн 5-н станцын (BOA2, UVA2, SEA3, HEA3, DOA3) хүлээн авагч дээр бүртгэж буй урт хугацааны статик өгөгдлийг (365 хоногийн 24 цагийн 30 минут тутамд) MONPOS цахим системд ороогүй байсныг 66.168.181.87 серверт автоматаар илгээгдэх тохиргоог 2025 оны 03 сарын 20-22 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шинжилгээг олон нийтэд нээлттэй ашиглах боломж бүрдүүлнэ. | | өдрүүдэд Баян-Өлгий, Увс, Дорнод, Хэнтий, Сэлэнгэ аймгуудын геодезийн асуудал хариуцсан мэргэжилтэн нартай хамтран зайнаас хандан ажиллаж гүйцэтгэсэн.<br>Геосет ХХК, Баясах Сүрвэй ХХК-ний хүсэлтээр GNSS-ийн хэмжилтийн өгөгдлийг MonPOS цахим систем ашиглан ITRF2020 солбицлын тогтолцоонд тэгшитгэн бодохдоо тус компаниудын хэмжилтийн багажны Олон улсын GNSS-ийн албанд шинээр бүртгэлтэй антен хүлээн авагчийн нэр, дугаарыг нөхцөл шалгах файлд нэмж оруулсан. | |
| 2.6.2.2 | GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын нэгдсэн удирдлагын системд шинэ станцын холболтын тоо нэмэгдүүлэх | Урсгал төсөв | 5 станц | 2019 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 43 станцын нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдүүлсэн.<br>2024 онд шинээр байгуулсан 5 станц нэмж нэгтэснээр байнгын ажилалаагаатай 48 станцыг удирдлагын нэгдсэн системд холбосон. | **Эхний хагас жилд:**<br>Одоо ашиглаж буй удирдлагын системд (SNIP-NTRIP) шинээр байгуулсан станцын холбоход шаардлагатай лицензийн тоог нэмэгдүүлэх төсвийн тооцоог гаргаж СЭЗХ-т хүргүүлэх<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Шинээр байгуулсан станцыг нэгдсэн удирдлагын системд холбох ажлыг зохион байгуулна. | GNSS-ийн байнгын ажиллагаатй суурин станцын удирдлагын программ дээр лицензийн тоог нэмэгдүүлэх урсгал төсвийн тооцоог СЭЗХ-т хүргүүлсэн боловч 2025 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцыг улсын төсвийн хөрөнгөөр шинээр байгуулах ажлын төсөв хасагдсан тул одоогоор нэгдсэн удирдлагын системд шинэ станц холбох хэрэгцээ шаардлага үүсээгүй байна. | |
| 2.6.2.3 | Ази-Номхон далайн бүсийн GNSS-ийн сүлжээний хэмжилтэд оролцох | Үйл ажиллагаа | Ази-Номхон далайн бүсийн геодезийн сүлжээний 6 станц | 2022 онд 6 цэгийн хэмжилтийн мэдээллийг Ази-Номхон далайн бүсийн геодезийн группт явуулсан. | **Сүүлийн хагас жилд:**<br>Ази-Номхон далайн бүсийн геодезийн холбоонд тухайн жилийн тэшигтгэн бодолтод оролцох Монгол Улсын GNSS-ийн байнгын ажиллагаатай 6 станцын сүлжээний хэмжилтийн өгөгдлийг шаардлагын дагуу бэлтгэн илгээнэ. | Хугацаа болоогүй<br>III-IV улирал | |
| 2.6.2.4 | ШУА-тай хамтран ООГФХ-ийн GNSS-ийн байнгын ажиллагаатай | Үйл ажиллагаа | 1 станц | ШУА-ийн ГФООХ-тэй хамтран ажиллах | **Сүүлийн хагас жилд:**<br>Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд ООГФХ-ийн Хөвсгөл | ШУА-ийн ГФООХ-ийн хариуцан ажиллуулдаг Хөвсгөл аймгийн Хатгал суманд суурилуулсан GNSS-ийн байнгын ажиллагаатай (htgg) станцыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | станцад засвар дамжуулалтыг тохиргоо хийх | | | гэрээг 2023 оны 08 дугаар сарын 31-нд байгуулсан. | аймгийн Хатгал сумын станцыг байгууллагын нэгдсэн сүлжээнд холбож тухайн байршилд бодит агшны засвар дамжуулалтаар (RTK) хангана. | тухайн сум суурин газарт геодезийн хэмжилт зураглалын RTK бодит агшны засвар дамжуулалтад ашиглахаар холбогдох албан хаагчидтай 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр уулзаж зайнаас хандан хамтран ажилласан боловч хоёр байгууллагын дотоод сүлжээний тохиргоог өөрчилж шинэчлэх шаардлага үүссэн тул мэдээлэл технологийн хэлтэстэй зөвшилцөж шийдэл гаргахаар ажиллаж байна. | |
| 2.6.2.5 | Газрын зургийн систем боловсруулах ТЭЗҮ боловсруулахад санал өгч, хамтран ажиллах | Улсын төсөв | ТЭЗҮ-1 | Геодези, зураг зүйн удирдлагын нэгдсэн системтэй болсон. Геодезийн хэмжилт, зураглалын багаж баталгаажуулалтын дэд систем хийсэн. | **Эхний хагас жилд:** Геодези, зураг зүйн системийг хөгжүүлэх Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах Ажлын даалгаварт санал өгсөн байна. ***Жилийн эцэст:*** Геодези, зураг зүйн системийг хөгжүүлэх Техник, эдийн засгийн үндэслэлийг холбогдох хурлаар хэлэлцүүлэх, батлуулах ажлыг зохион байгуулахад хамтран ажилласан байна. | Геодези, зураг зүйн системийг хөгжүүлэх Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах Ажлын даалгаварын төслийг 2025 оны 02 дугаар сард хянан, санал өгч засварлуулав. Геодези, зураг зүйн системийг хөгжүүлэх Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдаж, үнэлгээний хороонд ажиллан гүйцэтгэгчийг 2025 оны 04 сарын 07-ны өдөр сонгон шалгаруулж Ц.Дашзэвгэ ахлагчтай багтай гэрээ байгуулж ажлыг эхлүүлэв. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 2.7. Геодези, зураг зүйн цахим үйлчилгээ нэвтрүүлэх** | | | | | | | |
| **2.7.1** | **Газар зүйн нэрийн мэдээллийн дэд систем хөгжүүлэх** | **Улсын төсөв** | **Геодези, зураг зүйн цахим систем-5** | **Геопорталаар дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэх боломж бүрдсэн.** | **Цахим үйлчилгээ бүрэн нэвтэрсэн байна.** | | |
| 2.7.1.1 | Геодези, зураг зүйн цахим систем байгуулах | Улсын төсөв | 1 дэд цахим систем | GNSS-ийн хэмжилтийн өгөгдлийн тэгшитгэн бодолтын Монпос системийг 2020 онд хөгжүүлсэн. | **Эхний хагас жилд:** Геодези, зураг зүйн удирдлагын цахим дэд систем байгуулах Ажлын даалгавар боловсруулж, батлуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, ажлыг эхлүүлнэ. **Сүүлийн хагас жилд:** Геодези, зураг зүйн цахим системийн ажлын явцад хяналт | Геодези, зураг зүйн дэд системүүдийг хөгжүүлэх ажлын даалгавар боловсруулан, батлуулахаар Гадаад харилцааны яаманд 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн н/20 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Ажлын хэсгийг Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/76 дугаартай тушаалаар байгуулав. Геодези, зураг зүйн удирдлагын цахим системийг: -Улсын хилийн тэмдгийн цахим дэд систем, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тавих, үр дүнг шалгаж хүлээн авна. | -1:25000-1:50000-ны масштабтай байр зүйн зургийн цахим дэд систем,<br>-Газар зүйн нэрийн мэдээллийн цахим дэд систем зэрэг 3-н дэд системтэйгээр шинээр байгуулахаар ажлын даалгаварыг боловсруулж, холбогдох нэгжийн дарга нараас санал авч Газрын даргаар 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр АД/2025-52 дугаартай батлуулсан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар тендерийн баримт бичгийг боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Газрын даргаар батлуулав. Орон зайн систем хөгжүүлэлтийн чиглэлээр ажилладаг 4 компани руу 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн н/51 дугаартай албан бичгийг хүргүүлж, 4 компаниас 2025 оны 2025 оны 06 дугаар сарын 04-ний мэдээллээ ирүүлсэн. Системийн хөгжүүлэлтийг гүйцэтгүүлэх саналыг "Некст Жи Ай Эс" ХХК-д 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр н/60 дугаар албан бичиг хүргүүлэв. Үнийн саналыг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр хүлээн авч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулж ажлыг эхлүүлэв. | |
| 2.7.1.2 | Дунд масштабын газрын зургийн дэд систем байгуулах | Урсгал төсөв | 1 дэд цахим систем | GNSS-ийн хэмжилтийн өгөгдлийн тэгшитгэн бодолтын Монпос системийг 2020 онд хөгжүүлсэн. | **Эхний хагас жилд:**<br>Дунд масштабын газрын зургийн дэд систем байгуулах Ажлын даалгавар боловсруулж, батлуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, ажлыг эхлүүлнэ.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Дунд масштабын газрын зургийн дэд системийн ажлын явцад хяналт тавих, үр дүнг шалгаж хүлээн авна. | Дунд масштабын газрын зургийн дэд системүүдийг хөгжүүлэх ажлын даалгавар боловсруулан, батлуулахаар Гадаад харилцааны яаманд 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн н/20 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Дунд масштабын газрын зургийн дэд систем хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр АД/2025-52 дугаартай батлуулсан. Орон зайн систем хөгжүүлэлтийн чиглэлээр ажилладаг 4 компани руу 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн н/51 дугаартай албан бичгийг хүргүүлж, 4 компаниас 2025 оны 2025 оны 06 дугаар сарын 04-ний мэдээллээ ирүүлсэн. Системийн хөгжүүлэлтийг гүйцэтгүүлэх саналыг "Некст Жи Ай Эс" ХХК-д 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр н/60 дугаар албан бичиг хүргүүлэв. Үнийн саналыг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр хүлээн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулж ажлыг эхлүүлэв. | |
| 2.7.1.3 | Газар зүйн нэрийн мэдээллийн дэд систем байгуулах | Урсгал төсөв | 1 дэд цахим систем | GNSS-ийн хэмжилтийн өгөгдлийн тэгшитгэн бодолтын Монпос системийг 2020 онд хөгжүүлсэн. | **Эхний хагас жилд:**<br>Газар зүйн нэрийн мэдээллийн дэд систем байгуулах Ажлын даалгавар боловсруулах, батлуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, ажлыг эхлүүлнэ.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Газар зүйн нэрийн мэдээллийн дэд системийн ажлын явцад хяналт тавих, үр дүнг шалгаж хүлээн авна. | Газар зүйн нэрийн мэдээллийн дэд систем байгуулах ажлын даалгавар боловсруулан Гадаад харилцааны яаманд 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн н/20 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>2025 оны 03-05-р сарuудад Газар зүйн нэрийн мэдээллийн дэд систем байгуулах ажлын даалгаврыг шинэчлэн боловсруулж ГЗБГЗЗЕГ-ын даргаар 2025 оны 05 дугаар сарын 27-ний өдөр АД/2025-52 дугаартай ажлын даалгаврыг батлуулсан.<br>2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны жишиг баримт бичгийн дагуу ТББ-ийг боловсруулж ГЗБГЗЗЕГ-ын даргаар 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр батлуулсан. Орон зайн систем хөгжүүлэлтийн чиглэлээр манай байгууллагатай хамтран ажилладаг 4 компани руу 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн н/51 дугаартай албан бичгийг хүргүүлж, 4 компаниас 2025 оны 2025 оны 06 дугаар сарын 04-ний мэдээллээ ирүүлсэн. Системийн хөгжүүлэлтийг гүйцэтгүүлэх саналыг "Некст Жи Ай Эс" ХХК-д 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр н/60 дугаар албан бичиг хүргүүлэв. Үнийн саналыг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр хүлээн авч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулж ажлыг эхлүүлэв. | |
| 2.7.1.4 | Геодезийн сүлжээ, цэг, тэмдэгтийн мэдээллийн дэд систем байгуулах | Урсгал төсөв | 1 дэд цахим систем | Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн сан 2022 онд бүрдүүлсэн. | **Эхний хагас жилд:**<br>Геодезийн сүлжээ, цэг, тэмдэгтийн мэдээллийн дэд систем байгуулах Ажлын даалгавар боловсруулж, батлуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, ажлыг эхлүүлэх.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Геодезийн сүлжээ, цэг, тэмдэгтийн мэдээллийн дэд | Геодези, зураг зүйн дэд системүүдийг хөгжүүлэх ажлын даалгаврын ажлын иж бүрдэл хэсэгт Геодезийн сүлжээ, байнгын цэг, тэмдэгтийн мэдээллийн дэд системийн хөгжүүлэлт хийх шаардлага, иж бүрдлийг боловсруулав. Геодези, зураг зүйн дэд системүүдийг хөгжүүлэх ажлын даалгаврыг батлуулахаар Гадаад харилцааны яаманд 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн н/20 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | систем байгуулах ажлын явцад хяналт тавих, үр дүнг шалгаж хүлээн авна. | Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Ажлын хэсгийн 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/76 дугаартай тушаалаар байгуулав.<br>Геодезийн сүлжээ, цэг, тэмдэгтийн мэдээллийн дэд систем байгуулах ажлын төсөв цуцлагдсан тул 2026 оны төсөвт тусгуулахаар хойшилсон.<br>Геодезийн сүлжээний цэг тэмдэгтийн мэдээллийн санг 2026 оны төсөвд тусгахад шаардлагатай төсвийн тооцоо, төслийн асуумж хүснэгт, холбогдох мэдээллийн маягтыг бөглөн 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр СЭЗХ-ийн мэргэжилтэнд илгээв. | |
| 2.7.1.5 | Улсын хилийн тэмдгийн мэдээллийн дэд систем байгуулах | Урсгал төсөв | 1 дэд цахим систем | GNSS-ийн хэмжилтийн өгөгдлийн тэгшитгэн бодолтын Монпос системийг 2020 онд хөгжүүлсэн. | **Эхний хагас жилд:**<br>Улсын хилийн тэмдгийн мэдээллийн дэд систем байгуулах Ажлын даалгавар боловсруулж, батлуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, ажлыг эхлүүлнэ.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Улсын хилийн цэсийн мэдээллийн дэд систем байгуулах ажлын явцад хяналт тавих, үр дүнг шалгаж хүлээн авна. | Улсын хилийн тэмдгийн мэдээллийн дэд системүүдийг хөгжүүлэх ажлын даалгавар боловсруулан, батлуулахаар Гадаад харилцааны яаманд 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн н/20 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Улсын хилийн тэмдгийн мэдээллийн дэд систем байгуулах ажлын даалгаврыг боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 27-ний өдөр АД/2025-52 дугаартай ажлын даалгаврыг батлуулсан. Орон зайн систем хөгжүүлэлтийн чиглэлээр манай байгууллагатай хамтран ажилладаг 4 компани руу 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн н/51 дугаартай албан бичгийг хүргүүлж, 4 компаниас 2025 оны 2025 оны 06 дугаар сарын 04-ний мэдээллээ ирүүлсэн. Системийн хөгжүүлэлтийг гүйцэтгүүлэх саналыг “Некст Жи Ай Эс” ХХК-д 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр н/60 дугаар албан бичиг хүргүүлэв. Үүний саналыг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр хүлээн авч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулж ажлыг эхлүүлэв. | |
| 2.7.1.6 | GNSS-ийн өгөгдлийг ITRF2020 тогтолцоонд тэгшитгэн бодох Монпос системийн хөгжүүлэлт хийх | Урсгал төсөв | 1 дэд цахим систем | GNSS-ийн хэмжилтийн өгөгдлийн тэгшитгэн бодолтын Монпос системийг 2020 онд хөгжүүлсэн. | **Эхний хагас жилд:**<br>GNSS-ийн өгөгдлийг ITRF2020 тогтолцоонд тэгшитгэн бодох Монпос системийн хөгжүүлэлт хийх Ажлын даалгавар боловсруулж, батлуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, ажлыг эхлүүлнэ.<br>**Сүүлийн хагас жилд:** | GNSS-ийн статик хэмжилтийн өгөгдлийг ITRF2020 тогтолцоонд тэгшитгэн бодох Монпос системийн ажлын даалгаврыг боловсруулж бусад дэд системүүдийн ажлын даалгавартай нэгтгэн ГХЯ-руу батлуулахаар хүргүүлсэн.<br>Геодези, зураг зүйн удирдлагын цахим системийн хамрах хүрээнд GNSS-ийн өгөгдлийг ITRF2020 тогтолцоонд тэгшитгэн бодох Монпос системийн хөгжүүлэлт хийх ажлын даалгаврыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | GNSS-ийн өгөгдлийг ITRF2020 тогтолцоонд тэгшитгэн бодох Монпос системийн хөгжүүлэлт хийх ажлын явцад хяналт тавих, үр дүнг шалгаж хүлээн авна. | боловсруулсан боловч улсын төсвөөр хэрэгжүүлэх ажлаас хасагдсан тул 2025 онд хэрэгжүүлэх боломжгүй болсон.<br>Тус ажлыг 2026 оны төсвөөр хийх ажлын жагсаалтад оруулж шаардлагатай төсвийн тооцоо, төслийн асуумж хүснэгт, холбогдох мэдээллийн маягтыг бөглөн 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр СЭЗХ-ийн мэргэжилтэнд илгээв. | |
| 2.7.1.7 | Салбарын хэмжээнд ашиглагдаж буй агаар, сансрын зургийг боловсруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх | Үйл ажиллагаа | Салбарын хэмжээнд ашиглагдаж буй хиймэл дагуулын мэдээний төрөл | - 1:25000 масштабтай 45 сцен орто зураг;<br>- Landsat хиймэл дагуулын 1990 оны 85 сцен зураг;<br>- Монгол орныг бүхэлд нь хамарсан 2017 - 2018, 2021 оны GF-1, ZY-3 хиймэл дагуулын зурагт боловс-руулалт хийсэн; | **Эхний хагас жилд:**<br>Хиймэл дагуулын мэдээг хүлээн авч боловсруулан геопорталаар дамжуулан хэрэглээнд гаргасан байна.<br>Агаар, сансрын зургийг төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглуулах.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Агаар, сансрын ортофото, газрын гадаргын 3 хэмжээст тоон загварын мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх. | Хиймэл дагуулын мэдээг Орхон аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт шаардлагатай сансрын зургаар хангасан. Иргэн Д.Дамбын хүсэлтийн дагуу эзэмшил газрын сансрын зургийг он дараалын дагуу бэлтгэж 2025 оны 03 дугаар сарын 28-ний өдөр 2/1004 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Геопортал хөгжүүлэлт хийж байгаа тул иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу салбарын архиваас агаар, сансрын зургийг хэрэглээнд гаргаж төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглуулж байна. | |
| 2.7.1.8 | Газар зүйн нэрийг полигонжуулах, арга аргачлал боловсруулах ажил (Сүхбаатар аймаг) | Урсгал зарпал | Ажил-1, Арга аргачлал-1 | 2021-2022 онд Сүхбаатар аймгийн газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажил хийсэн. | **Эхний хагас жилд:**<br>Газар зүйн нэрийг полигонжуулах, арга аргачлал боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлыг эхлүүлсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>Газар зүйн нэрийг полигонжуулах, арга аргачлал боловсруулах ажлын үр дүнг шалгаж хүлээн аван Геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгнө. | "Газар зүйн нэрийг полигонжуулах, арга аргачлал боловсруулах ажил (Сүхбаатар аймаг)"-ын Ажлын даалгаврыг боловсруулан Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр АД/2025-05 дугаартайгаар батлуулсан. Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/38 дугаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулсан. Тендерийн зарыг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр худалдан авах ажиллагааны https://tender.gov.mn/ цахим системд нийтэлсэн. 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр тендерийг хүлээн авч, нээсэн. 3 оролцогчийн ирүүлсэн тендерийг хянан үзэж, үнэлэн шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр тендер шалгаруулалтыг дахин зарласан.<br>Дахин зарласан тендер шалгаруулалтыг 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр нээсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Инженер геодези" ХХК-ийг сонгон шалгаруулж, Гэрээ байгуулах эрх олгох 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/220 дугаар тушаал батлуулж, гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. | |

## ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратегийн төлөвлөгөөний зорилго 3.1. Улсын хил шалгалтын ажлыг зохион байгуулах** | | | | | | | |
| **3.1.1** | **Монгол Улс, ОХУ хоорондын улсын хил шалгахад зориулан геодези, зураг зүйн ажил хийх** | **Улсын төсөв** | **3543 км урт улсын хил** | **Монгол Улс, ОХУ хоорондын улсын хилийг шалгаж, зураглах ажил 2023 оноос эхлүүлсэн.** | **Монгол-Оросын улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын гэрээний хэрэгжилтийг хангаж УИХ-аар батлуулах баримт бичгийг бэлтгэж батлуулсан байна.** | | |
| 3.1.1.1 | Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг хамтран шалгах Засгийн газар хоорондын хамтарсан Комиссын үйл ажиллагаанд оролцох | Үйл ажиллагаа | 3 хурал | Засгийн газрын 2021.09.15-ны өдрийн 289-р тогтоолоор Монгол улс, Оросын Холбооны Улсын хилийг шалгах 2 улсын Засгийн газар хоорондын хамтарсан комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Хамтарсан комиссын 4 удаагийн хурал 2022-2023 онд зохион байгуулагдсан. | **Эхний хагас жилд:**<br>Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг хамтран шалгах Засгийн газар хоорондын хамтарсан Комиссын геодези, байр зүйн хамтарсан Ажлын хэсгийн хуралд оролцоно.<br>Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг хамтран шалгах Засгийн газар хоорондын хамтарсан Комиссын 7-р хуралд оролцоно.<br>Комиссын хурлаар хэлэлцэх асуудлын төсөлд санал боловсруулна.<br>**Жилийн эцэст:**<br>Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг хамтран шалгах Засгийн газар | Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг хамтран шалгах Засгийн газар хоорондын хамтарсан Комиссын геодези, байр зүйн хамтарсан Ажлын хэсгийн IV хуралдаан 2025 оны 2 дугаар сарын 18-21-ний өдрүүдэд ОХУ-ын Эрхүү хотноо зохион байгуулагдав.<br>Ажлын хэсгийн монголын талын төлөөлөгчдийг Монгол Улс, ОХУ хоорондын улсын хилийг шалгах Монгол-Оросын хамтарсан комиссын Монголын хэсгийн дэд дарга, ГЗБГЗЗЕГ-ын дарга А.Энхманлай тэргүүлж, ГЗЗХ-ийн дарга Д.Мөнхцэцэг, ахлах мэргэжилтэн В.Отгонбаяр нар оролцов.<br>Геодези, байр зүйн хамтарсан Ажлын хэсгийн хуралд Монголын талаас 10, оросын талаас 9 төлөөлөгч оролцож, хурлаас гарсан шийдвэрийг баталгаажуулан протокол үйлдэж 2 талын төлөөлөгчдийн тэргүүн нар гарын үсэг зурав.<br>Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах Монгол-Оросын хамтарсан комиссын дарга нарын уулзалт 2025 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хоорондын хамтарсан Комиссын 8-р хуралд оролцоно. Комиссын хурлаар хэлэлцэх асуудлын төсөлд санал боловсруулна. | оны 05 дугаар сарын 19-24-ний өдрүүдэд Москва хотноо зохион байгуулагдав. Дарга нарын уулзалтад Монгол Улс, ОХУ хоорондын улсын хилийг шалгах Монгол-Оросын хамтарсан комиссын Монголын хэсгийн гишүүн, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын ГЗЗХ-ийн дарга Д.Мөнхцэцэг оролцов.<br>Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг хамтран шалгах Засгийн газар хоорондын хамтарсан Комиссын 7-р хурал 2025 оны 06 дугаар сарын 23-27-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдахаар товлогдож Монголын хэсгийн н/03/033 дугаар албан бичгийг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр ирүүлэв. Албан бичгийн дагуу Комиссын 7-р хурал дээр танилцуулах мэдээллийг бэлтгэж 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдсан Монголын хэсгийн хуралд танилцуулж, 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр хамтарсан Комиссын 7-р хуралд танилцуулав. | |
| 3.1.1.2 | Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах Ажлын хэсэгт ажиллах | Үйл ажиллагаа | 1 ажил | Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах ажлын хүрээнд байрлалын сүлжээ, өндрийн сүлжээ байгуулах ажлыг 2023 онд эхлүүлсэн. | **Эхний хагас жилд:**<br>Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах зорилгоор 2023-2024 онд хийгдсэн хилийн тэмдэг байршуулах, геодези, байр зүйн зургийн ажлын үр дүнд шалгалт хийх Ажлын хэсэгт ажиллана. | Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах Монгол-Оросын хамтарсан Комиссын Монголын хэсгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/021 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу I улиралд хилийн тэмдгийн солбицлын жагсаалт гаргах, 2023, 2024 онд хэмжсэн хилийн тэмдгийг ХХЕГ-ийн хилийн тэмдэг суурилуулсан тайлантай тулган шалгах, солбицлын зөрүүтэй хилийн тэмдгийн жагсаалт гаргах, хилийн тэмдгийн мэдээллийн санг бүрдүүлэх, солбицлын зөрүүг магадлан шалгах ажлыг гүйцэтгэж, Ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулав.<br>Тус ажлын хэсэг байгуулагдсан цагаас хойшхи хугацаанд магадлан шалгах ажлын хэсгийн хийсэн ажил, санал, дүгнэлт, цаашид хийх суурин болон хээрийн хэмжилтийн ажлын талаар дэлгэрэнгүй танилцуулгыг боловсруулж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | илтгэл бэлтгэж ажлын хэсгийн даргад танилцуулав.<br>А/021 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн улсын хилийн тэмдгийн байршлыг магадлан шалгасан ажлын явцыг хэлэлцэх хурлыг 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр ГЗБГЗЗЕГ дээр зохион байгуулав.<br>Тус хурлын тэмдэглэл протоколыг хөтөлж 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн н/39 дугаар албан бичгээр Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах Монгол-Оросын хамтарсан Комиссын Монголын хэсэгт хүргүүлэв. | |
| 3.1.1.3 | Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах, зураглах ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | 5 ажил | Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах ажлын хүрээнд байрлалын сүлжээ, өндрийн сүлжээ байгуулах ажлыг 2023 онд эхлүүлсэн. | **Эхний хагас жилд:**<br>Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах зорилгоор хийгдэх геодези, байр зүйн зураглалын ажлын даалгавар боловсруулж батлуулан, ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажлын үр дүнг шалгаж хүлээн авна.<br>- Байрлалын сүлжээ байгуулах;<br>- Хилийн тэмдгийн солбицол, өндөр тодорхойлох;<br>- Өндрийн сүлжээний холболтын хэмжилт;<br>- 1:25000, 1:50000-ны масштабтай байр зүйн зураглал;<br>- GNSS-ийн байнгын ажиллагаатай станц суурилуулах;<br>- Хэвлэлийн тоног төхөөрөмж худалдан авах;<br>- Техник хэрэгсэл худалдан авах.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах зорилгоор хийгдэх геодези, | - Монгол Улс, ОХУ хоорондын улсын хил шалгах зорилгоор хийгдэх геодези, байр зүйн ажлын сонгон шалгаруулалт зохион байгуулах зөвшөөрөл авахаар 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн н/18 дугаар албан бичгийг ТЕГ-т хүргүүлэв. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр А/76 /нууц/ дугаар тушаалаар байгуулав.<br>- Геодези, байр зүйн ажлын даалгавар, техникийн тодорхойлолт боловсруулан 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн н/18, 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн н/20 дугаартай албан бичгээр хилийн Комиссын Монголын хэсгийн даргаар батлуулахаар хүргүүлэв.<br>- Монгол Улс, ОХУ-ын өндрийн сүлжээг 1991-1993 онд холбож хэмжсэн хэмжилтийн өгөгдөл, тайлан материалыг ОХУ-ын Холбооны улсын бүртгэл, кадастр, зураг зүйн агентлагаас зохих журмын дагуу гаргуулан авахад дэмжлэг хүсэн 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 1/883 дугаар албан бичгийг ГХЯ-нд хүргүүлэв.<br>- Монгол Улс, ОХУ-ын хил шалгалтын хүрээнд харилцан хяналтын хэмжилт хийх оросын талын байгуулсан байрлал-өндрийн үндэслэлийн 5 цэгийн жагсаалт, хувийн хэрэг, хэмжилтийн журналыг бэлтгэн Комиссын Монголын хэсэгт 2025 оны 04 дүгээр сарын 01- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байр зүйн зураглалын ажлын үр дүнг шалгаж хүлээн авна. | ний өдрийн н/23 дугаартай албан бичгээр хүргүүлэв.<br>- Монгол Улс, Оросын Холбооны Улсын хил шалгалтын хүрээнд Оросын талын байгуулсан байрлал-өндрийн үндэслэлийн 4 цэг дээр харилцан хяналтын хэмжилтийг Комиссын Монголын хэсэг, ГЗБГЗЗЕГ-ын албан хаагчдаас бүрдсэн баг 2025 оны 04 дүгээр сарын 14-19, 05 дугаар сарын 18-23-ны өдрүүдэд гүйцэтгэж тайланг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн н/58 дугаар албан бичгээр Комиссын Монголын хэсэгт хүргүүлэв.<br>- Хил шалгалтын ажилд ашиглах GNSS-ийн хүлээн авагч багажны техникийн тодорхойлолтыг 2025 оны 04 дүгээр 25-ны өдөр газрын даргаар батлуулж, 5 ширхэг иж бүрдэл багаж худалдан авах үнийн саналыг 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 1/1471 дугаартай албан бичгийг 4 аж ахуй нэгжид хүргүүлж, “Агар-Од инженер” ХХК-иас 4 багаж худалдан авахаар гэрээ байгуулсан. Багажийг Булган, Баян-Өлгий, Дорнод, Хөвсгөл аймгийн ГХБХБГ-т хүлээлгэн өгч, тус аймгуудын геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд 2025 оны 06 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд сургалт зохион байгуулав.<br>- Хэвлэлийн тоног төхөөрөмж болон плоттерын судалгаа хийж холбогдох аж ахуйн нэгжүүдээс албан бичгээр саналыг 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 1/984, 1/1987, 1/988 дугаар албан бичгийн Монголын хэвлэлийн үйлдвэрүүд, хэвлэн нийтлэгчдийн холбоо, “Мөнхийн үсэг” ХХК, “Адмон принтинг” ХХК-д, 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр “Вертексмон” ХХК, “Сайнинтернэйшнл” ХХК-д 1/1643, 1/1644 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br>- Хэвлэлийн тоног төхөөрөмж (плоттер)-ийн техникийн тодорхойлолт боловсруулж 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр ГЗБГЗЗЕГ-ын даргаар батлуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Хэвлэлийн төхөөрөмж нийлүүлэх, угсрах, хэвийн ажиллагааг хангах, өрөөг засварлах ажлын тендерийн баримт бичгийг боловсруулан Газрын даргаар 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр батлуулсан.<br>- Хэвлэлийн тоног төхөөрөмж (плоттер) нийлүүлэгчээр "Би Си Ти" ХХК-ийг сонгон шалгаруулж 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 2025/85 дугаар гэрээг байгуулсан.<br>- "Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийн дагуу геодезийн сүлжээ байгуулах, байр зүйн тоон зураг зохиох, улсын хилийн багана, тэмдгийн солбицол, өндрийг тодорхойлох" (Багц 1)-ийн эхлэлийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн ГЗЗХ-2025/07 дугаартай дүгнэлтээр Геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгөв.<br>- Улсын хил шалгах геодези, байр зүйн ажил гүйцэтгэх 3 аж ахуйн нэгжийн албан хаагчдад зориулсан сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж, тайланг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн н/57 дугаар албан бичгээр хамтарсан комиссын Монголын хэсэгт хүргүүлэв. | |
| 3.1.1.4 | Хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулах | Үйл ажиллагаа | 3 гэрээ, санамж бичиг | 2019 онд 2 улсын Засгийн газар хоорондн геодези, зураг зүйн салбарт хамтран ажиллах хэлэлцээрийн төслийг боловсруулан 2021 онд эцэслэн хоёр тал холбогдох байгууллагын саналыг авсан. | **Эхний хагас жилд:**<br>Монгол Улс, Оросын Холбооны Улсын Росреестр байгууллагатай геодези, зураг зүйн салбарт хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулж ГХЯ-нд хүргүүлнэ.<br>**Жилийн эцэст:**<br>Монгол Улс, Оросын Холбооны Улсын Росреестр байгууллагатай геодези, зураг зүйн салбарт хамтран ажиллах гэрээ байгуулахад хамтран ажиллана. | Росреестр байгууллагатай байгуулах хамтын ажиллагааны санамж бичгийн төслийг англи хэл дээр оросын талаас 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр оросын талаас хүлээн авч монгол хэл дээр орчуулав.<br>Орос хэл дээрх хувилбарыг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хүлээн авав.<br>Оросын талаас ГХЯ зэрэг бусад байгууллагын саналыг авсны дараа албан ёсоор манай талд ирүүлэхээр хүлээгдэж байна.<br>Росреестр байгууллагатай байгуулах хамтын ажиллагааны санамж бичгийн төсөлд нэгжийн дарга нараас санал авч, ГХЯ-наас санал авахаар 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 1\.... дугаар албан бичгээр хүргүүлэв. | |
| 3.1.1.5 | Олон улсын зураг зүйн холбоонд геодези, зураг зүйн чиглэлээрх | Үйл ажиллагаа | 1 тайлан | Олон улсын зураг зүйн холбоонд гишүүнчлэлийн | **Эхний хагас жилд:**<br>Геодези, зураг зүйн чиглэлээр 2023 онд хийсэн ажлын | Олон улсын зураг зүйн холбооны National Reports International Cartographic Association веб хуудсаар дамжуулан зураг зүйн холбоонд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тайлан хүргүүлэхтэй хамтран ажиллах | | | төлбөрийг 2023 онд шилжүүлсэн. | талаарх тайланг Олон улсын зураг зүйн холбоонд ОУЗЗХ-нд хүргүүлнэ. | тайлан илгээсэн гишүүн орнуудын тайлантай танилцаж судалгаа хийсэн.<br>Геодези, зураг зүйн үйл ажиллагаатай холбоотой зураг зүй, газар зүйн нэр, GNSS-ын байнгын ажиллагаатай станц, 1:1000-ны масштабтай байр зураг, Монгол Улсын нутаг дэвсгэрийг 1:25000-ны масштабтай байр зургаар зурагжуулах, өндөр болон гравиметрийн сүлжээний талаар тайланг нэгтгэж 2025 оны 06 дугаар сарын ...-ны өдөр ..... дугаар албан бичгээр хүргүүлсэн. | |
| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | засварлаж ирэх шаардлагатай гэж шийдвэрлэсэн. “Усны ёроолын геодезийн хэмжил, зураглалын ажил” БД-ийг ГЗЗОТБМЗХ-аар 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр хэлэлцэж дэмжигдсэн. 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 2/2031 албан бичгээр барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн.<br>4. ХББОСЯ-ны ШУТТЗ-ийн хурлын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 01-3/2025 дугаартай шийдвэрээр “Геодези, зураг зүйн ажлын техникийн тайлан, төсөл бичих заавар” БД-ийг Геодзи, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.12-т заасныг үндэслэн ГЗБГЗЗЕГ-ын даргын тушаалаар батлуулахаар шийдвэрлэсэн.<br>5. “Хот суурин газрын өндөржилт төлөвлөлт хийх геодезийн ажил” БД-ийг батлуулахаар 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 2/2990 дугаартай албан бичгээр “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-т хүргүүлсэн. БХТ-өөс ХББОСЯ-нд хүргүүлж ШУТТЗ-ийн хурлаар хэлэлцэхээр хүлээгдэж байна. | |
| 3.4.1.2 | “Геодезийн хэмжих хэрэгслийн загвар турших, баталгаажуулах журам”-ын төслийг боловсруулах | Үйл ажиллагаа | 1 журам | - | **Эхний хагас жилд:**<br>“Геодезийн хэмжих хэрэгслийн загвар турших, баталгаажуулах журам”-ын төслийг боловсруулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>“Геодезийн хэмжих хэрэгслийн загвар турших, баталгаажуулах журам”-ын төслийг холбогдох хурлаар хэлэлцүүлж баталсан байна. | Монгол Улсын Хэмжил зүйн тухай хууль, Стандарт, хэмжил зүйн газраас хууль эрхийн хэмжил зүйн олон улсын байгууллага (OIML)-аас гаргасан баримт бичиг, зөвлөмжийн дагуу шинэчлэн боловсруулсан Хэмжих хэрэгсэлд загварын туршилт хийх журам, Хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийх журмыг судалсан.<br>Журмын төслийг геодезийн хэмжих хэрэгслийн нарийвчлал, загварыг турших, үр дүнг баталгаажуулах, бүртгэх дэд системийн хөгжүүлэлтийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4.1.3 | Лабораторийн “Чанарын гарын авлага”-ын журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актад бүртгүүлэх | Үйл ажиллагаа | 13 журам | 2024 онд Геодезийн хэмжлийн багаж баталгаажуулах цахим систем ашиглалтад орсон. | **Эхний хагас жилд:**<br>Лабораторийн үйл ажиллагаанд мөрддөг журмуудыг нэмэлт, өөрчлөлт оруулан шинэчлэн батлуулна. | Үндэсний итгэмжлэлийн төвөөс "Баримт бичгийн үзлэгт хийсэн тайлан"-ийн үзлэгээр гаргасан зөвлөмжийг тусган лабораторийн үйл ажиллагаанд мөрддөг “Чанарын гарын авлага”-д нэмэлт өөрчлөлт оруулж Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/78 дугаар тушаалаар батлуулсан.<br>Лабораторид хийсэн магадлан итгэмжлэлийн үнэлгээгээр “Ажилтны журам”-гүй гэсэн үл [illegible] холбогдох газар, хэлтсүүдээс санал авч тусган 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Газрын даргын А/122 дугаар тушаалаар баталж, лабораторийн “Чанарын гарын авлага”-д нэмж оруулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан. | |
| **3.4.2** | **Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг 1:25000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулах** | **Улсын төсөв** | **Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55% хувийг зурагжуулах, 913872.4 км$^2$ нутаг дэвсгэрийн 10914 хуудас 1:25000-ны масштабтай байр зүйн тоон зураг.** | **2020 онд Монгол Улсын нутаг дэвсгэрийн 45%-ийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулж, 7328 хуудас зураг хийгдсэн.** | **Хэрэглэгчдэд шуурхай хүргэж, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн байр зүйн болон баталгаажсан нэг маягийн суурьтай сэдэвчилсэн газрын зураг, атласаар хангана.** | | |
| 3.4.2.1 | 1:25000-ны масштабтай байр зүйн зургийн таних тэмдгийн стандартыг шинэчлэх | Үйл ажиллагаа | MNS 6703 : 2017. Байр зүйн зургийн загвар сан, таних тэмдэг. Масштаб: 1:25000, 1:50000, 1:100000<br>MNS *6702* : 2017. Байр зүйн болон дэвсгэр | 1:25000-ны масштабтай байр зүйн зургийн 293 давхаргын таних тэмдгийн загвар сан бүрдээгүй. | **Эхний хагас жилд:**<br>1:25000-ны масштабтай байр зүйн зургийн таних тэмдгийн стандартыг шинэчлэх судалгаа хийнэ.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>1:25000-ны масштабтай байр зүйн зургийн таних тэмдгийн стандартыг шинэчлэн боловсруулна. | 1:25000-ны масштабтай байр зүйн зургийн таних тэмдгийн хөгжүүлэлт хийх ажлыг ОХУ-ын таних тэмдгийн загвар санг орчуулан Монголын улсын таних тэмдгийн загвар сантай харьцуулсан судалгаа хийсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зургийн загвар сан, таних тэмдэг. Масштаб: 1:500, 1:1000, 1:2000, 1:5000 | | | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 3.7. Газрын харилцааны салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах, нэгдсэн удирдлагаар хангах** | | | | | | | |
| **3.7.2** | **Салбарын хууль тогтоомж шинэчлэн батлагдахтай холбогдуулан шаардлагатай эрх зүйн бусад актыг шинэчлэн боловсруулах, батлуулах** | **Үйл ажиллагаа** | **нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл** | | **Газрын тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, холбогдох байнгын хороо, УИХ-аар хэлэлцүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж, хуулийн төслүүдийг батлуулахад холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна.** | | |
| 3.7.2.1 | Салбарын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулах, санал өгөх, батлуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл | | **Эхний хагас жилд:** Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулах **Сүүлийн хагас жилд:** Хуулийн төслийг холбогдох байнгын хороо, УИХ-аар хэлэлцүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж, хуулийн төслийг батлуулахад холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна. | Геодези, зураг зүйн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдан Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт, нэмэлт оруулах санал боловсруулав. | |

## ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|

| | бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1 | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | Үйл ажиллагаа | Үүрэг даалгаврын тоо | Жил бүр хийгддэг. | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнасан байна. | ГЗБГЗЗЕГ-ын Дотоод арга хэмжээний төлөвлөгөөнд туссан "Монгол цэргийн өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулав.<br>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг урьдчилсан байдлаар 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр гаргаж тайлагнав.<br>Эхний хагас жилд нийт 21 удаагийн шуурхайгаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлж тайлагнасан. | |
| 4.1.2 | Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | Үйл ажиллагаа | Тушаалд заасан хугацаа | Жил бүр хийгддэг. | Ажлын хэсэгт ажиллаж, хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан байна. | Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах Монгол-Оросын хамтарсан Комиссын Монголын хэсгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/021 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, батлагдсан удирдамжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу тухай бүр биелэлтийг Ажлын хэсгийн даргад тайлагнав.<br>2025 оны А/76 дугаар Ажлын хэсэгт ажиллаж, худалдан авах ажиллагааны журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, Захиалагчид зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг тайлагнаж байна.<br>2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/106 дугаар тушаалаар байгуулагдсан багаж хүлээн авах Комисст ажиллаж, тоон нивелир (Инвар рейк, бусад дагалдах иж бүрдлийн хамт)-ийг техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагын дагуу актаар баталгаажуулан 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр хүлээн авч, тушаалд заасан хугацаанд хэрэгжилтийг хангав.<br>2025 оны А/179 дүгээр тушаалаар "Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийн дагуу геодезийн сүлжээ байгуулах, байр зүйн тоон зураг зохиох, улсын хилийн багана, тэмдгийн солбицол, өндрийг тодорхойлох" ажлын хүрээнд хилийн боомтуудын ойролцоо | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байрлах оросын талын нутаг дэвсгэрт байгуулсан байрлал, өндрийн үндэслэлийн 2 цэгт харилцан шалгалтын хяналтын хэмжилт хийсэн.<br>2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/201 дугаар тушаалд заасан багаж, тоног төхөөрөмжийг актаар хүлээн авсан.<br>2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/210 тушаалд заасны дагуу сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж, санхүүгийн тайланг СЭЗХ-т хүргүүлж тушаалын биелэлтийг хаав.<br>2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/217 тушаалд заасны дагуу хэлэлцүүлгийг 2025 оны 06 дугаар сарын 02, 06 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулсан. | |
| 4.1.3 | Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах | Үйл ажиллагаа | Тогтоол, шийдвэрийн тоо | Жил бүр хийгддэг. | Холбогдогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан байна. | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн судалгааны биелэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр гаргаж, ГСШБТГ-т хүргүүлж тайлагнасан.<br>Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг 2025 оны 05 дугаар сарын 25-нд тайлагнав. | |
| 4.1.4 | Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | Үйл ажиллагаа | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо | Жил бүр хийгддэг. | Нэгжид ирсэн хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлыг заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Эхний хагас жилд 244 албан бичиг ирснээс хариугүй 108, хариутай 136, 18 өргөдөл, гомдол ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн. | |
| 4.1.5 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | Үйл ажиллагаа | Архивт хүлээлгэн өгсөн баримтын тоо | Жил бүр хийгддэг. | Нэгжийн урьд онд хийсэн ажлын баримт бичгийг тайлант оны эхний улиралд багтаан байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна. | Геодезийн хэмжил зүйн лабораторид 2024 онд 1288 хэмжих хэрэгсэлд баталгаажуулалтад хүлээн авах, олгох хуудас бичигдэн Архивт баримт бичиг хүлээлгэн өгөх журамд заасны дагуу баримт бичгийн иж бүрдлийг ханган байгууллагын архивт 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр хүлээлгэн өгсөн. | |

## Нэмэлт ажил, үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (Арга хэмжээ) 1.Улсын хилийн багана тэмдгийн протокол дээрх солбицлыг газар дээр нь тогтоон байршлыг тодорхойлох | | ХХЕГ-ын багийн бүрэлдэхүүнтэй хамтран ажиллаж нөхцөл байдлын талаар мэдээллэж тайлагнах | Хил Хамгаалах Ерөнхий Газраас 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 2а/44 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улс, Оросын холбооны Улс хоорондын улсын хилийг II дах удаагаа хамтран шалгах ажлын хүрээнд Увс аймгийн Тэс, Баруунтуруун сумдад 2025 оны 01 дүгээр сарын 15-наас 24-ний өдрийн хооронд 9 хоног томилолтоор ажиллаж Увс, Дөрөө нуурын орчмын улсын хилийн багана тэмдгийн протокол дээрх солбицлыг газар дээр нь тогтоох байршлыг тодорхойлох ажлыг гүйцэтгэсэн. | |
| 2. | Үүрэг даалгавар (Арга хэмжээ.) 2.Орон нутагт хэрэгжүүлэх геодези, зураг зүйн салбарын үйл ажиллагааг сурталчлах, эрчимжүүлэх | Танилцуулга, сургалт | Газрын харилцааны удирдах ажилтны зөвлөгөөнд оролцож, хамтран зохион байгуулах | ГЗБГЗЗЕГ болон 21 аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга, удирдлагын хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын зохион байгуулсан “Газрын харилцааны салбарын удирдах ажилтны зөвлөгөөн – 2025” арга хэмжээнд Геодези, зураг зүйн хэлтсийн даргын танилцуулах илтгэлийг хамтран боловсруулж, Геодези зураг зүйн чиглэлээр бодлогын баримт бичиг тусгагдсан арга хэмжээ, хэрэгжилт, тулгамдаж буй асуудлууд, санал зөвлөмж, “олон улсын туршлага”, “шилдэг туршлага” сэдвийн хүрээнд илтгэл танилцуулсан. Хэлэлцүүлэг зохион байгуулж, санал, зөвлөмж гаргаж албажуулан аймгуудын ГХБХБГ, НГЗБА-нд тус тус хүргүүлсэн. | |
| 3. | Үүрэг даалгавар (Арга хэмжээ) 3.Геодезийн хэлтсийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах | Рийл бичлэг, постер | Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх, сурталчлахад хамтран ажилласан байна. | 2025 оныг Иргэдийн оролцоог дэмжих жил болгон зарласантай холбогдуулан байгууллага, хэлтсийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, богино хэмжээний рийл, контентод оролцож багаж баталгаажуулалтын төлбөр, Хэмжих хэрэгслийг бусдад шилжүүлэх, газар зүйн нэр сэдвийн хүрээнд 3 танилцуулга хийсэн. | |
| 4. | Үүрэг даалгавар (Арга хэмжээ) 4.Авлигатай тэмцэх газарт нотлох баримт хүргүүлэх | Албан бичиг | Ирүүлсэн хүсэлтийн дагуу нотох баримт гаргаж хүргүүлнэ. | Авлигатай тэмцэх газраас 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдөр ирүүлсэн албан хүсэлтийн дагуу албан бичигт дурдсан цэгүүдийн солбицолтой холбоотой нотлох баримтыг Газрын даргын 1/553 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | |
| 5. | Үүрэг даалгавар (Арга хэмжээ) 5.ШУТИС-ын Геологи, Уул уурхайн сургуулийн "ГЕОДЕЗИ 2025" эрдэм шинжилгээний хуралд хамтран ажиллах | 1 өдөр | Шүүгчээр ажиллаж танилцуулсан ЭШӨ-дэд шүүмж, зөвлөгөө үнэлгээ дүгнэлт өгч ажиллана. | 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр ШУТИС болон 5D WORLD ХХК-ын хамтын ажиллагааны хүрээнд зохи он байгуулсан Геологи Уул уурхайн сургуулийн 65 жил,Геодезийн тэнхимийн 45 жил, профессор А. Дамдинсүрэнгийн 80 насны ойд зориулсан CHCNAV 5D WORLD ХХК нэрэмжит "ГЕОДЕЗИ 2025" оюутны эрдэм шинжилгээний хуралд Шүүгчийн үүрэгтэй оролцож Газрын харилцааны салбарын залуу боловсон хүчин болохоор бэлтгэгдэж буй оюутан залуусын 14 эрдэм шинжилгээний өгүүллэг, илтгэлийг уншиж, сонсож, шүүмж зөвлөмж өгч ажилласан. | |
| 6. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6. Байгууллагын веб хуудсыг шинэчлэх | 1 мэдээ | Байгууллагын веб хуудаст байгаа Зураг зүй, газар зүйн нэртэй холбоотой мэдээллийг шинэчилнэ. | Зураг зүй болон газар зүйн нэртэй холбоотой байгууллагын веб хуудаст байрших мэдээллийг шинэчилж 2025 ны 02 дугаар сарын 14-ний өдөр Мэдээлэл, технологийн хэлтэст хүргүүлсэн. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7. | Үүрэг даалгавар (арга хэмжээ)<br>7. Үнэлгээний хороонд ажиллах | 4 тендер | Тендерийг амжилттай шалгаруулсан байна. | Газар зүйн нэрийг полигонжуулах, арга аргачлал боловсруулах ажил (Сүхбаатар аймагт), Хаягийн тэмдэг, тэмдэглэгээний стандартыг шинэчлэх, норм дүрэм, арга аргачлал боловсруулах ажил, Газрын кадастрын мэдээллийн сангийн архивын мэдээлэл болон нэгж талбарын өөрчлөлтийн түүхчилсэн лавлагааг хялбаршуулах, цахимжуулах ажил, Газрын зургийн системийн техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ боловсруулах ажил зэрэг 4 ажлын үнэлгээний хорооны даргаар ажиллаж 3 тендер амжилттай шалгарч, гэрээ байгуулсан. | |
| 8. | Үүрэг даалгавар (арга хэмжээ)<br>8. ХБНГУ | 1 төлөвлөгөө | Хамтран ажиллаж өөрийн талаас дэмжлэг үзүүлсэн байна. | Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бонн хотод зохион байгуулагдах НҮБ-ын Дэлхийн орон зайн мэдээллийн менежментийн мэргэжилтнүүдийн хорооны Геодезийн дэд хорооны (UN-GGIM Subcommittee on Geodesy) 5 дугаар хуралд оролцож, дэлхийн геодезийн сүлжээ байгуулах төлөвлөгөө боловсруулахад санал өгөв. Дэлхийн геодезийн сүлжээ байгуулах төлөвлөгөөг Монгол Улсад хэрэгжүүлэх төлөвлөгөө, хороо байгуулахаар баримтыг бэлтгэж байна. | |
| 9. | Үүрэг даалгавар (арга хэмжээ)<br>9. Мэргэшсэн, Зөвлөх инженерийн зэрэг горилох, сунгах мэргэжилтнүүдээс шалгалт авах, дүгнэх | 1 шалгалт | Шалгалтыг амжилттай зохион байгуулсан байна. | Мэргэшсэн, Зөвлөх инженерийн зэрэг горилох, сунгах мэргэжилтнүүдээс шалгалт авах, дүгнэх үүрэг бүхий Ажлын хэсэгт 2025.02.10-14-ний хооронд ажиллаж геодези, зураг зүйн Мэргэшсэн, Зөвлөх инженерийн зэрэг горилох, сунгах мэргэжилтнүүдээс авах шалгалтын материал бэлдэж шалгалт авсан. | |
| 10. | Үүрэг даалгавар (арга хэмжээ)<br>10. Үндэсний атласын агуулга тодорхойлж, боловсруулах | 1 танилцуулга | Атласын агуулга тодорхойлж, боловсруулна. | "Монгол Улсын Үндэсний атлас"-ын агуулгыг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлж, боловсруулах үүрэг бүхий ажлыг хэсгий Монгол Улсын Зөвлөх зэрэгтэй инженерүүдээс санал авч боловсруулан ГЗБГЗЗЕГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/125 дугаар тушаалаар байгуулсан.<br>Ажлын хэсэг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр, 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр тус тус хуралдаж атласын агуулгыг хэлэлцэн боловсруулсан. "Монгол Улсын Үндэсний атлас"-ыг шинээр зохиох ажлын танилцуулгыг бэлтгэж удирдлагад танилцуулав. | |
| 11. | Үүрэг даалгавар (арга хэмжээ)<br>11. Үндэсний итгэмжлэлийн төвөөс геодезийн хэмжил зүйн лабораторид хийсэн магадлан итгэмжлэлийн үнэлгээгээр илэрсэн зөвлөмж, үл тохирол залруулах | 3 үл тохирол, 7 зөвлөмж | MNS ISO/IEC 17025:2018 стандартын 6.2.5-т заасан шаардлагад нийцсэн байна. | Геодезийн хэмжил зүйн лабораторид илэрсэн 3 үл тохирол, 7 зөвлөмжийг "Залруулах, сэргийлэх ажиллагааны журам"-д заасны дагуу залруулах ажлын төлөвлөгөө боловсруулж, 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Газрын даргаар батлуулсан.<br>Төлөвлөгөөнд заасан хугацаанд 7 зөвлөмж, 3 үл тохирлыг залруулан 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр 1/1518 дугаар албан бичгээр үнэлгээний ажлын хэсэг, итгэмжлэлийн үндэсний төвд хүргүүлсэн. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12. | Үүрэг даалгавар (арга хэмжээ)<br>12. Монгол Улс, БНХАУ хоорондын улсын хил шалгалтын ажлын хэмжээ, төсвийн тооцоо гаргах | Заасан хугацаанд | Тухай бүрд өгөгдсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэнэ. | Монгол Улс, БНХАУ хоорондын улсын хил шалгалтын ажлын хэмжээ, төсвийн тооцоо хилийн дагуух геодези, байр зүйн ажлын \өндрийн II ангийн 7077 км (шууд, урвуу) урттай, 10 шугамтай сүлжээг байгуулж, Хятадын өндрийн сүлжээтэй 796 км урттай (шууд, урвуу) 6 шугамаар өндрийн холболтын хэмжилт, Хиймэл дагуулын байнгын ажиллагаатай 10 станц байгуулах, байрлалын сүлжээ байгуулах, байр зүйн зураг зохиох, улсын хилийн багана, тэмдгийн солбицол, өндөр тодорхойлох\ тоо хэмжээ, төсвийн тооцоог гаргаж, танилцуулгын хамт ГХЯ-нд 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр мн/62 албан бичгээр хүргүүлэв. | |
| 13. | Үүрэг даалгавар (арга хэмжээ)<br>13. Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах, зураглах ажлыг зохион байгуулах | Холбогдох журамд нийцсэн байна. | Тухай бүрд өгөгдсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэнэ. | "Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийн дагуу геодезийн сүлжээ байгуулах, байр зүйн тоон зураг зохиох, улсын хилийн багана, тэмдгийн солбицол, өндрийг тодорхойлох" Багц 2, Багц 3 ажлын гүйцэтгэгч нарт хилийн багана, тэмдгийн жагсаалт, өмнөх онд хэмжсэн солбицол өндрийн жагсаалт, шинээр суулгах тэмдгийн жагсаалт, улсын хилийн шугам, газар зүйн холболт хийсэн байр зүйн зургийг ялган бэлтгэж, 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн н/42, н/43 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв. | |
| 14. | Үүрэг даалгавар (арга хэмжээ)<br>14. Байгууллагын албан хаагчдын зуслангийн газарт цахилгааны түгээлтийн техникийн нөхцөл авах ажлын бэлтгэл хангах | - | Заасан хугацаанд хэрэгжилтийг хангана. | Байгууллагын албан хаагчдын Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны Ар хөндлөнгийн аманд байрлах зуслангийн газарт цахилгааны түгээлтийн техникийн нөхцөл авахад шаардлагатай баримт бичгийг газар эзэмшигч тус бүрээс хүлээн авч, нийт 124 газар эзэмшигчийн газрын гэрчилгээ, иргэний үнэмлэхний лавлагаа, хуулбарыг нэгтгэж ТЗУГ-т 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр хүргүүлж, хэрэгжилтийг хангав. | |
| 15 | Үүрэг даалгавар (арга хэмжээ)<br>15. Шинэтгэлээр түүчээлсэн төрин албаны зөвлөл яаны хүрээнд төрийн албыг сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах | 1 сургалт арга хэмжээ | Тухай бүрд өгөгдсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэнэ. | Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 15 дугаар тушаалаар батлагдсан "ШИНЭТГЭЛЭЭР ТҮҮЧЭЭЛСЭН САЛБАР ЗӨВЛӨЛ" аяны хүрээнд Төрийн албаны зөвлөлийн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлөөс баталсан төлөвлөгөөний дагуу "Төрийн албаны нөөцөд байгаа иргэн болон их дээд сургуульд суралцаж буй оюутан, ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад Монголын төрт ёсны түүхэн уламжлал, төрийн албаны онцлог, бахархал, төрийн албанд ажиллахын давуу талыг сурталчлах арга хэмжээг зохион байгуулах" ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Геодези мэргэжлээр суралцаж буй 2-4 дүгээр курсын 30 гаруй оюутнуудад төрийн албаны онцлог, бахархал, төрийн албанд ажиллахын давуу талыг сурталчлан танилцуулсан. | |

## ТАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ | Хүрэх түвшин | Хэрэгжүүлсэн ажил | Эхлэх, дуусах огноо |
|---|---|---|---|---|

| “ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | |
|---|---|---|---|---|
| 5.1. | Геодезийн Мэргэшсэн, Зөвлөх инженерүүдэд зориулсан сургалтад хичээл заах | 1 удаа хичээл заасан байна. | Геодезийн Мэргэшсэн, Зөвлөх зэрэг олгох, сунгах сургалтад “ГЗЗ-н салбарын хууль эрх зүйн орчны шинэчлэлт”, “Газар зүйн нэр”, “Монгол орны геоидын өндрийн загвар” сэдвээр материал бэлтгэж хичээл заасан.<br>ШУТИС-ийн геодезийн 2-4-р курсын оюутнуудад “Геодези, зураг зүйн үйлдвэрлэлийн удирдлага, зохион байгуулалт” хичээл заав. | 03.09 – 03.15 |
| 5.2. | Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | Шинээр гарсан хууль, дүрэм, журам, тогтоол, шийдвэртэй тухай бүр танилцаж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн байна. | Худалдан авах ажиллагааны сургалтад сууж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмуудыг судлав. Худалдан авах ажиллагааны шалгалт өгч А3 сертификат авав.<br>Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахтай холбогдуулан 2024-2025 онд батлагдсан хуулийн судалгаа хийв. | 01.02 – 12.30 |
| 5.3. | Геодезийн Мэргэшсэн, Зөвлөх инженерүүдэд зориулсан сургалтад хичээл заах | 1 удаагийн хичээл заасан байна. | Хугацаа болоогүй | 10-11 сар |
| 5.4. | Байгууллагаас болон төслөөс, олон улсын байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдах | Мэдлэг, чадвараа дээшлүүлсэн байна. | Байгууллага дээр зохион байгуулагдсан Төрийн болон албаны нууцын тухай хууль, журам, түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, Кибер аюулгүй байдлын сургалт, “Аз жаргалтай гэр бүл” сэдэвт сургалтад хамрагдсан. | 1-5 сар |
| 5.5. | Дотоодын болон олон улсын хурал, зөвлөгөөнд оролцож мэдлэг, мэдээлэл авах | Мэдлэг, мэдээлэл авсан байна. | Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бонн хотод 2025 оны 03 дугаар сарын 10-14-ний хооронд зохион байгуулагдсан НҮБ-ын Дэлхийн орон зайн мэдээллийн менежментийн мэргэжилтнүүдийн хорооны Геодезийн дэд хорооны (UN-GGIM Subcommittee on Geodesy) 5 дугаар хуралд НҮБ-ын зардлаар оролцож, дэлхийн улсуудын Геодезийн асуудал хариуцсан агентлагууд, олон улсын байгууллагуудын тавьсан илтгэлтэй танилцаж мэдээ, мэдээлэл авав.<br>Сургалтын дагуу үндэсний геодезийн хороо байгуулахаар салбарын Зөвлөх, мэргэшсэн инженерүүдийг хамруулсан уулзалт, семинарыг 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөж хөтөлбөр, оролцогчдын нэрсийн жагсаалт гаргав. | Тухай бүр |